

МОНГОЛЫН СУДЛАЛ БА ХАСУМИ ХАРУО
ПРОФЕССОРЫН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ

Д.Галбаатар*

Дэлхийн Монгол судлалын салбарт хэдүйн нэрд гарсан Японы монголч эрдэмтэн-шинжээч Хасуми Харуо профессорын Монгол угсаатны хэл, түүх, ёс заншил, соёл урлаг, аман болоод бичгийн уран зохиолыг судлах өргөн хүрээтэй ажил, амьдралын анхны гараа эхэлснээс хойш 50 жил хэдүйн өнгөрчээ.

Хасуми профессор 1960 онд Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн Монгол хэлний нэгдүгээр ангийн оюутан, жаахан хүү гүйж явжээ. Жаал хүү Хасуми Харуо оюутан болсон өдрөөс эхлэн өөрийн биеийн амар жаргалыг огоорон идэх хоол, унтах нойрыг хугаслан сууж, эртний өрлөг их түүх соёлт Монголын эзэнт гүрэн хийгээд алдар цуу нь дэлхий дахинаа мандан бадарч асан хүчирхэг эзэн хаан Чингис Богд болон Их газрын тал хээр нутагтаа морин дэл дээр аж төрж дассан атлаа хаа холын Наран улс руу далай гатлан довтолж асан түүний удам угсааны их хаадын үүх түүхийн мөрийг мөшгин судлаж, шимтэн уншиж, баясан бахдаж явсан гэдэг. эдүгээ ч эртний зориг цөс ихт өвөг дээдсийнхээ гал голомтыг дээдлэн суугаа Монгол улс хийгээд эртний түүхийн өш гэсгээл, тавилан таалалаар өөр өөр улс гүрний харъяа, хяналтанд аж төрдөг ч үндэснийхээ бичиг, түүх соёлыг дээдлэн хадгалж, уламжлалт ёс заншил, хэв төрхөө бүхий л талаар хамгаалан хөгжүүлж суугаа нийт монгол үндэстний сурвалжит түүх, утга зохиол, аман зохиолын эрт эдүгээгийн байдлыг судлан сурвалжлах ном эрдмийн мөрөөр олон жилийн цуцалтгүй зүтгэсэн хөдөлмөрийнх нь тайланг Хасуми профессорын шавь залгамжлагчид санаачлан, өнөөдөр ёс төртэй тэмдэглэж байгааг би хувьдаа нүдээ олсон баяртай үйл явдал хэмээн Профессор танд чин сэтгэлээсээ баяр хүргэж байгааг хүлээн авч ажаамуй.

Монголчууд ертөнцийн буурал түүхийн хайр хишиг, хал зэмийг хангалттай амсаж, мандаж буурч, доройтож, сэргэж ирэхдээ олон мянган жилийг элээсэн бөгөөд хангай, говь, тал хээр хосолсон өргөн уудам бүс нутагт дөрвөн улирлын өнгө эрхшээлийг дагаж эрх дураараа нүүдэллэн амьдрах явцдаа үндэстний хувьд бүрэлдэн төв Азийн нүүдлийн өвөрмөц соёл иргэншлийг хүн төрөлхтний түүхнээ бүтээсэн их ард түмэн билээ.

Монголын судлалтан нарын хэдийн хэлсэн нэгэн иш үгийг өчүүхэн засамжилж хэлбэл алс барууншаа долоон усны газар “*Касту хүртэл*” -аас Нанхиад, Тангуд, Гуулин, Бирм, Наран улс, Вьетнамын зарим нутаг хүртэл Номхон дөлгөөн гадаад их

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

далайн өмнөд хийгээд умард, зүүншээх гурван эргийн хооронд аж төрж асан олон улс гүрэн, дундад Ази, Энэтхэг хийгээд ойрхи Дорнодын бүс нутаг дахь ертөнцийн хүмүүний хөгжил дэвшилийн цаашдын зам мөрд түүхэн эргэлт гаргаж, алдаа оноо хослуулсан их байлдан дагуулалтын сүр дуулиан хэдий холын явдал боловч тэрхүү дайн тулааны хожмын үр нь ОХУ, Хятад зэрэг томоохон гүрнүүдийг буй болгоод зогссонгүй бүр өдгөөгийн Европын холбоо хийгээд Лалын ертөнцийг нэгэн дээврийн дор нэгтгэх эрмэлзлэг нь дэлхий ертөнцийг глобалчлах үзэл санааны үүдэл, үүд хаалга нь байсан байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Ямар ч гэсэн өнөөдөр монголчуудын хувьд Мөнх хөх тэнгэрийн (түүхийн) зарлигаар хийсэн аян дайны үйлийг харгис хэрцгий хэмээн дүгнэдэг боловч тэрхүү улиглалаас аажим алгуур ангижран, уг түүхэн үйл явц хүмүүн төрөлхтний цаашдын хөгжил дэвшилд ямар сайн үр ашиг өгөв гэдэг асуудалд шинээр сэтгэгч эрдэмтэд илүү их анхаарал талбих болсон нь баярлалтай. Энэ бол монголын судлалыг хуучин шиг улс төр, үзэл суртлын нөлөө, хуваагдмал байдалтай бус жинхэнэ ёсоор нь бодитой хөгжүүлэх үнэлэж дүгнэх өргөн бололцоо олгож байгааг харуулж байна.

Монголчуудын түүх соёл нь эрт эдүүгээ олон улс үндэстэн угсаатны сэргэн мандах, бууран доройтох, мөхөн сөнөх үйл явц, түүхэн хувь заяа, ялж ялагдсны түүх намтартай олон талаараа холбогддог учраас монголын судлал дэлхий дахины анхаарлыг татсан, олон мэргэдийг төрүүлсэн судалгааны том объект болж чадсаныг өдгөө үгүйсгэх аргагүй болжээ. Тиймээс ч Монголчуудын түүх, соёлыг судлах ажлын явцад түүнд таатай, таагүй байдлаар хандах, зөвшөөрөх, үгүйсгэх, эргэлзэх, төөрөлдөх, янз бүрийн үзэл баримтлал үргэлжид солбицолдон оршиж, газар газрын эрдэмтдээс Монголчуудын угсаа гарал, түүх намтарт хандах байр суурь, хувийн үзэл бодлын улбаа мөр, бүтээл туурвилд нь нөлөөлөн илрэх зэрэг нь нэн элбэг төдийгүй уг судлагдахуун ээдрээ түвэгтэй, олон улс үндэстний үүх түүх, эрх ашгуудын мөргөлдөөн дунд хөгжиж байгаа тул хүнд хэцүү салбар төдийгүй нүүдлийн соёл иргэншилд нэн зохицсон монгол хэл, түүх соёл, угсаатны болон зан үйл, аж төрөх ёс, шашин шүтлэг, гүн ухаан, танин мэдэхүй өв туршлага, тулж тэмцэх хийгээд оршин амьдрахуйн зарчим, сэтгэлгээний хэв маяг гэх зэрэг тэдний бүтээсэн эрдэм мэдлэгийн өв санг сайтар эзэмшихийг захын судлаачаас шаардаж, томоохон эрдэмтний билиг ухаан, зориг тэвчээрийг шалгадаг салбар гэж болох билээ. Тийм ч учраас Хэн дуртай хүн барьж аваад судлачих амар хялбар судлагдахуун биш бөгөөд ямагт өөрийнхөө эн далайцад дүйх тулх нуруутай, зузаан мэдлэг, билгийн хараатай томоохон эрдэмтдийг Монголын судлал түүхийнхээ бүхий л үед шаардсаар ирсэн гэж би ойлгодог юм. Тийм эрдэмтэд Монгол судлалын түүхэнд олон төрсөн бөгөөд Тэдний дунд Японы эрдэмтэд зүй ёсоор ордог юм. Япон Улсын ахмад үеийн эрдэмтдийн залгамж халаа болсон тийм эрдэмтний нэг нь профессор Хасуми Харуо багш болно.

Хасуми Харуо профессорын монгол хэл дээр хэвлэгдсэн шинжилгээ судалгааны сонирхолтой бүтээлүүд болон монголын талаар бичсэн өгүүлэл, тэмдэглэл, орчуулга, нийтлэлийн бусад бүтээлүүд бидний анхаарлыг байнга татаж байдаг юм. Түүний дотроос профессор Хасуми Харуо гуайн Монголчуудын гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл, аж төрөх ёс, шашин шүтлэг, соёл, урлаг, утга зохиол, шинжлэх ухаан, угсаатны зүйн тал бүрийн мэдлэг ухааныг өөртөө нэгтгэсэн баялаг өв болох Монгол аман зохиолын судалгаа голлох байртай нь түүнийг японы бусад судлагчдаас ялгаруулдаг гэж болно. Ялангуяа Монголын төрт ёсны түүхийн нэгэн үеийг багтаасан, үгийн урлагийн гайхамшигт бүтээлийн нэг *“Монголын Нууц Товчоо”*-г дотоод гадаадад цөөнгүй

эрдэмтэн олон талаас нь системтэй судлан шинжилж, орчуулан хэвлэж, харьцуулан судалсаар байгаа бөгөөд түүний нэг нь Профессор Хасуми Харуо гуай юм. Тэр тусмаа “МНТ”-ны доторх аман зохиолын зүйлсийг удаан хугацаагаар дагнан судалж байгаа нь монголын аман ба бичгийн уран зохиолын харилцан холбоо, хамаа нөлөөллийн асуудлыг гүнзгийрүүлэхэд онол, түүхийн хувьд ихээхэн үнэ цэнтэй бүтээл болох төдийгүй орчин үеийн аман зохиол, бичгийн уран зохиолын холбооны асуудлыг ч тодотгоход арга зүйн ач холбогдолтой судалгааны ирээдүйтэй чиглэл гэж үзэж байна.

Энэ хурал дээр илтгэл тавьсан олон эрдэмтэд Монгол аман зохиол хийгээд “МНТ”-ны аман зохиол судлалын асуудлаар бодитой үнэлгээ өгч, сайтар тодруулан өгүүлсэн тул товчлоод нэгэн зүйлийн талаар товч өгүүлэхийг хүсч байна

Хасуми профессор “МНТ” дахь аман зохиолын баримт жишээг ерийн нэг бүртгэн судалж байгаа биш тэрхүү хэрэглэгдэхүүндээ тулгуурлан монгол шүлгийн урлах арга, бүтэц байгуулалтын асуудал хийгээд хэмжээ, хэмнэл, айзам зүй, эгшиглэл зүй цаашилбал бадаглал зүйн асуудлуудыг хөндөн аман зохиол, уран зохиолын харилцан нөлөөлөл ба гарвал зүйн асуудлыг ч анхаарч байгаа нь түүний судалгааг өргөн хүрээтэй болгож байдаг билээ. Түүний хамт үгийн гарал, утга зүйн шинэ сэргэг тайлбар тэрчлэн монгол хүнд хялбар боловч гадаадын хүн ойлгоход бэрхтэй монгол зан үйлийн нарийн ширийн зүйлийг гярхай ажиглан олж нухацтай тайлбарлан таниулахад анхаарч байгаа нь оюутан, аспирант, докторант, залуу судлагчдад эрдэм шинжилгээний ажлын чухал санаа, эх хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой байна. Түүний бүтээлийн ийм нийлэг олон талт бүтцийг бид “Судар тэмдэглэл Хүннүгийн намтар дахь нэгэн хэрэг”, “Судар тэмдэглэл”-ийн 110-р боть Хүннүгийн намтарын 50-р тал дахь бичил бичвэрт хийсэн ажиглалт ба тэнд “*адуу*”, “*саарал морь*” (өрнө), “*бор морь*” (дорно), “*хар морь*” (умар), “*улаан морь*” (өмнө) гэсэн нь зөвхөн цэргийн хүч чадал зохион байгуулалттай холбоотой биш яагаад тэдгээр зүсмийн онцлосон гэдгийг баатарлаг туульсын морьдын өнгөтэй холбон судалсан ба тэр зуур хүлэг морьтой холбоотой зан үйлийн тайлбар хийгээд түүнтэй шууд холбоотой “*ар, өвөр, хөндий, хөх борлог адуу*” г.м (олон үгийн утгыг тайлбарласныг үзнэ үү) бүтээлээр нь төлөөлүүлж болно.

Хасуми профессор зөвхөн эрдэмтэн төдийгүй монгол хэл хийгээд монгол зан үйлийн ертөнцөд нэлээд гүн нэвтэрч байгаа нь мөн өгүүлэл дэх адууны зүс ба зүсэмийн ялгааг оновчтой тайлбарласнаас үзэж болно. Зүс нь голдуу адууны үндсэн зүс буюу өнгөний байдлыг шууд заадаг бол зүсэм нь ойр төс бүхий зүсүүдийг нэгтгэн нэгэн бүхлийг заасан утгатайг баатарлаг туулийн жишээгээр гайхалтай тайлжээ. Гадаадын хүнд монгол өнгө ба ялангуяа малын зүс, зүсмийн тухай ойлголт хийгээд түүний бэлгэдэл, илэрхийллүүдийн систем маш хүнд юм. Миний бие аливаа нэг орон судлалтан хүнд хамгийн түрүүн байх гол зүйл бол тухайн үндэстний хэлний төгс мэдлэг гэж үздэг нэгэн билээ. Энэ шалгуурт Хасуми Харуо профессор төдийгүй нийт япон эрдэмтэн судлагчид монгол бичиг, шинэ үсэг, ярианы ба бичгийн хэлийг эзэмших талаар бусад ямар ч орны эрдэмтдийг дагуулахгүй түвшинд хүрсэнд баярлаж бас гайхан биширдэг юм. Одоогийн байдлаас үзэхүл барууны болон Орос европын ахмад үеийн том эрдэмтэд ертөнцийн жамаар цөөрч, шинэ үеийн эрдэмтдийн дийлэнх олонх нь монгол хэлний зохих түвшний мэдлэг эзэмшиж чадаагүй, монголчуудын уламжлалт зан уламжлалыг бага мэддэг болсноос зөвхөн номоос номонд дамжуулан тандан (таамаглан) судлах, зөөвөрлөн хуулах, янз бүрийн хувилбар орчуулгуудын ялгаа зөрүүг тогтоох, хуучны судлалын бүтээлүүдийг харьцуулах, тодорхой бүтээлд эх бичгийн

судалгаа хийх зэрэг уламжлалт түвшнээс урагш төдий л ахиж чадахгүй байгаа нь хэлний бэрхшээлтэй холбоотой гэж боддог юм.

Миний хувьд Хасуми Харуо профессорыг зөвхөн аман зохиол судлалтан төдийгүй монголын соёл урлагийг Япон Улсад сурталчлах талаар ихийг хийсэн хүн гэж боддог. Ялангуяа Монголын язгуур урлагийн өвийг залгамжлагч нэрт дууч, хөөмийч, хуурч, хөгжмийн зохиолчдыг урьж тоглолт хийлгэх, *“Монгол зураг”*(1985), *“Монгол гар урлал”* (1987), *“Монгол уран барилга”*(1988), *“Монгол уран баримал”* (1990), болон *“Монголын мал аж ахуйтан”* (1993) зэрэг монголчуудын том хэмжээний цуврал бүтээлүүдийг цөөн жилийн дотор япон орчуулга тайлбартайгаар хэвлүүлсэн төдийгүй энэ их ажлын завсар чөлөөгөөр *“Монголчуудын үг хэл-аман зохиол”*, *“Чингис хааны домог”* судалгааны олон бүтээл туурвиж, *“Монголын аман зохиолын судлал”* хэмээх том хэмжээний анатологи (цоморлиг)-ийг япон хэлнээ орчуулж монголын эхийг хавсарган хэвлүүлсэн нь Японы аман зохиол судлагч залуу эрдэмтэд хийгээд орчуулагч нарт сайхан жишээ, монголчуудын хувьд завшаантай хэрэг болсон юм.

Нөгөө талаар Хасуми багш төрөлх сургуулийнхаа Монгол судлалын салбарт багшлан Монголын залуу судлалтан нарыг бэлтгэхэд өөрийн ухамсарт амьдралыг зориулсан ахмад сурган хүмүүжүүлэгч хүн ажээ. Зөвхөн Японы Монгол судлалын залгамж халааг төдийгүй Өвөрмонгол хийгээд Монгол улсын оюутан мэргэжилтэн нарыг судалгааны арга зүй эзэмшиж, монголын судлалд зүрх сэтгэлтэй болоход нь ТГСИС-ийн Монгол судлалын салбарын эрдэмт профессор, багш нартайгаа хамтран хичээн зүтгэсээр байгаад талархал дэвшүүлэх ёстой.

Өөр нэг онцлох зүйл бол би өдгөө хүртэл Хасуми профессорыг зөвхөн *“МНТ”*-ны аман зохиол судлалыг дагнадаг гэж бодсон билээ гэтэл *“Монгол шүлэг ба шүлэгчид”* хэмээх аман ба бичгийн яруу найргийн холбоо хамаарлын ерөнхий зүй тогтлыг харьцуулж, тоймлон гаргасан багашаархан боловч сонирхолтой өгүүлэл бичснийг уншсан юм. Сонирхолтой гэсний учир бол уг өгүүлэлд судлагч Монголын уран зохиол ба аман зохиолын талаар өөрийн баримталдаг концепцийг нэлээд тодорхой тавьжээ. Түүнээс үзвэл уг эрдэмтэн

1. Монголчууд өөрийн аман зохиолтой тэр нь олон мянган жилийн өв уламжлалтай. (Монголчуудын үгийн урлагийн ноёрхогч хэлбэр нь аман зохиол гэсэн санаа Д.Г)

2. Монголчууд нааш ч үгүй цааш ч үгүй 1204 онд бичиг үсэгтэй болсон тэр цагаас хойш бичгийн уран зохиолтой болсон ч тэр нь аман зохиолдоо захирагдмал явсаар 1921 оны хувьсгалын дараагийн хэсэг хугацаанд ч аман зохиол гол үүрэгтэй байсан гэж үздэг байна. *“1204 оноос өмнөх монгол бол бичиг үсэггүй нийгэм байсан юм. Энэ нь түүнээс өмнө үеэс уламжлагдаж ирсэн буй бүхүй утга зохиол нь аман зохиол байлаа гэсэн явдал болно. Бичиг үсэгтэй боллоо ч гэсэн тэр нь тун цөөхөн хүмүүсийн л юм байжээ. Зонхилох олон ард иргэн бол мөн л аман уламжлалын ертөнцдөө байлаа гэснийг хэлж байгаа юм”* (мөн тэнд 134-р тал).

3. Монголын эртний ноёлогч ангид бичгийн уран зохиол нь хамаатай ард иргэн дор аман зохиол хамаатай байсан *“Үсэг танигч давхрага бол бичгийн утга зохиолыг уг болгож, аман зохиолыг болхи юм гэж байв. Түүгээр ч барахгүй ноёрхогч ангийнхан аман зохиолыг бас дайсагнан үзэж байсан юм”* *“Монголын нууц товчоо”*-ны аман зохиол судлал. Өвөрмонгол. 1999. (140-р тал).

4. Аман зохиол бичгийн уран зохиол хоёр ижил үүрэг зорилготой бөгөөд монголын аман ба бичгийн уран зохиол нь холилдомол (нийлэг) шинжтэй (*“МНТ”* дахь

үргэлжилсэн үгийн зохиолуудын дунд орсон яруу найргийг бүр ардын аман зохиол гэж хэлж болох юм” гэх мэт) гэсэн дүгнэлтүүд миний бодлоор нотолгоо муутай боловч үлэмж “зоригтой” дүгнэлт юм.

Яагаад ингэв гэхээр зарим нь эргэлзээ төрүүлмээр (бичгийн зохиол ноёрхогч цөөнхийн, аман зохиол ард иргэний байсан ба хоорондоо тэмцэлдэж байсан гэсэн дүгнэлт миний үзэл баримтлалтай зөрж байгаа юм. Минийхээр бол аман зохиол ч тэр бичгийн уран зохиол ч тэр аль алинд нь ноёрхогч анги ба ард иргэний гэсэн үзэл санааны хоёр чиглэл байсан билээ. Д.Г (зарим нь маргамаар (Монголын судлагчид аман зохиолоо маш эртний гаралтай хүлээн зөвшөөрч бас бичгийн уран зохиолыг баяжуулан баялагжуулах үндсэн эх ундрага гэж үзэхийн хамт бичгийн уран зохиолын түүхийг лавтай мэдэгдэж байгаа үе буюу 800 жилийн тэртээгээс тооцдог. Энэ үе бол монголын аман ба бичгийн уран зохиол салбарлан салсан үе байсан билээ. Аман зохиол бичигт тэмдэглэгдэн дамжиж эхлэхээрээ аман зохиолын мөн чанараа алддаг гэсэн үзэл онол ч байдаг. Гэтэл Хасуми багшийнхаар энэ үеийг шарын шашны бичиг зохиолын зүйлс ихэд дэлгэрсэн 18-19-р зуун руу татан “энд аман зохиол ба бичгийн зохиолын салбар зам байсан юм” (139-р тал) гэжээ. Аман ба бичгийн уран зохиол миний хувийн бодлоор лавтайгаар 800 жил хамт зэрэгцэн (харилцан нөлөөлж) хөгжсөн. Харин бичгийн ба аман зохиол нь өнөөг хүртэл хоёулаа зэрэгцэн амьд хөгжиж байгаа үгийн урлагтай ард түмэн цөөхөн гэдэгтэй маргахгүй байх (заримыг асуумаар (Судлагч “Монголчууд бид 4000 жилийн адууны соёлтой гэж бардам хэлдэг” (217-р тал) гээд дараагийн мөрөнд “Хуучин Тангийн бичигт” тэдний өвөг дээдсийн тухай тэмдэглэл нь “хамгийн анх тэмдэглэгдсэн бөгөөд...адуу маллаж байсан” гэсэн мэдээг ашиглан монголчууд “наад зах нь 1000 гаруй жилийн адууны соёлтой гэдэг зайлшгүй” гэж дүгнэсэн байна. Одоогоор мэдэгдэж байгаа баримтыг өгүүлж байна уу? Аль эсвэл “Хүннү монгол угсаатан уу”, Түрэг угсаатан уу?, аль эсвэл бүр ондоо угсаатан уу? гэсэн эргэлзээнээс болж 1000 гаруй гэдэг тоог тогтоов уу...? (гэх мэт нягтлууштай дүгнэлтүүд байгаа нь Хасуми профессорын судалгаа шинжилгээний ажил олон талтай төдийгүй шинэ сэргэг, зоримог санаатай, түүнийхээ ул үндсийг ярган үзэх гэсэн хүсэлтэй нь холбоотойн илэрхийлэл юм. Энэ мэт монголыг судлагчдыг өдөөн дуудаж, маргаан мэтгэлцээн өрнүүлэх, харилцан шүүмжлэлцэж судалгааг мухарлах, шүүмжлэл сонсох, бас шүүмжлэлтэй хандах нь судалгаа шинжилгээний ажлын нэг чухал тал, мөн чанар, дүр төрх байдаг билээ.

Мэдээж хэрэг аливаа судлалтны эрдэм шинжилгээний бүтээлүүд цөмөөрөө алдаа эндэгдэлгүй ариун дээд үнэн болчихдоггүй зүй тогтол бий. Хасуми Харуо багшийн бүтээл ч түүнээс ангид биш буйзаа.

Хасуми профессорын үйл ажиллагаа олон талтайг дээрх баримтууд харуулахын зэрэгцээ түүний судалгаа шинжилгээний ажлын чиглэлийг бодоод зөвхөн монгол хэл заах арга зүй, аман зохиол судлалын гэж ойлгох нь хэтэрхий явцуу бөгөөд түүний судалгааг нарийн харах юм бол аман зохиолын судлалд нь угсаатны мэдлэг шаардсан тайлбарууд (Жишээ нь: “Монгол хүн ба морины ертөнц” өгүүллийн морь таних эрдэм ба түүний нууц, төрөл хэлбэрийг амьд баримтад тулгуурласан (Зан үйлийн болон аж төрөх ёс, идэх уухын ёс дэг, уламжлал (Жишээ нь: “Монголын орчин үеийн яруу найргийн бүтэц хэлбэрийн талаар өгүүлэх явцдаа Монголчуудын мал аж ахуйн уламжлалт хэлбэрээ дагаад жилийн дөрвөн улирал малыг ашиглах, арчлах, хүнс тэжээл бэлтгэх зэрэг), уран сайхны орчуулга хийсэн (Б.Явуухулан “Тэхийн зогсоол” найраглал г.м (угсаатны судлал, ардын билэг зүй, түүгээр ч зогсохгүй үгийн гарлын

судалгаа шинэ санал, таамаглал зэргийг үндсэн өгүүлэмжтэйгээ зохицуулан чөлөөтэй ашигласан, тэрчлэн арга зүйн чанартай сонирхолтой аргыг олж чаддаг (Жишээ “МНТ” дахь “Цээл усан ширгэв. Цэгээн чулуу хагарав (цуурав)” гэдэг өвөрмөц хэллэг “МНТ”-нд анх хэрэглэгдсэн бус харин бүр эрт үед “ширгэхгүй”, “хагарахгүй” гэж боддог байсан үед аман зохиолд байсныг ийн ашигласан гэх мэт), Монголын судлалд Хятадын эртний сурвалж бичиг материалыг ашиглахын чухлыг сануулсан, судлагдахуунаа гүнзгийрүүлэн бодож үзэгдлийг олон талаас нь нямбай шинжиж зөв баталгаа гаргах зэрэг чадвар нь шавь нарын нь өвлөн үлдүүштэй эрхэм гол чанар юм.

Ийнхүү монголчуудын оюуны соёлын өв уламжлалыг аман зохиолоос нь улбаалуулан судлах чиглэлээр олон тооны шилдэг бүтээл туурвиж олон мэргэдийн анхааралд толилуулахын зэрэгцээ Бичгийн уран зохиолын доторх аман зохиолын судалгааны шинэ чиглэлийг бий болгож тэр зүгт өөрийн болоод шавь залгамжлагчдын хүчийг төвлөрүүлж байгаа явдал нь Хасуми Харуо багшийн монголын утга соёлын судлалд оруулсан гол хувь нэмэр бөгөөд Япон дахь монгол судлал төдийгүй нийт монголын судлалд оруулсан хувь эрдэмтний 40 жилийн бүтээлч үйл ажиллагааны үр дүн гэж баттай хэлж болно.

“Чингисийн цадиг” хэмээх сударт:

Буулгаагүй модонд балт сайн сүх хэрэг

Буулган барваас зохиогч сайн уран хэрэг

Байгуулаагүй төрд баатар сайн хүн хэрэг

Байлган барваас бясалгагч сайн сэцэн хэрэг

хэмээн айлдсан билээ. Хасуми Харуо профессор хөндөгдөөгүй шахам байсан “МНТ”-ны аман зохиол судлал хэмээх “модыг буулгаж” баржээ. Бас буулгасан модоо нарийн шинжиж “зохиогч сайн уран” болжээ. Гагцхүү судалгааны энэ шинэ чиглэлийг шинжлэх ухаанд хэрхэн авч явах нь “бясалгагч сайн сэцэн” шавь нарын хэрэг болжихуй.

Таны эрдэм мэдлэг, билэг авъяас улам ундарч, судалгаа шинжилгээний ажил тань өргөжин гүнзгийрч, амьдрал үйлс тань ямагт жаргал дүүрэн өлзийтэй байхын билэгт ерөөлийг талбияа.